

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар-НЭГ: Инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, ус, дулаан цахилгаан хангамжаар байгууллага, иргэдийг тасалдуулахгүй, гэнэтийн гэмтэл, саатал, гарахаас урьдчилан сэргийлэх, шуурхай ажиллагааны бригад, жижүүрийн хуваарь гарган, хяналт тавьж, болзошгүй осол, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх.				
1.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны Сандэй-28 дугаар байрны Төв түгээх төвийн харьяа 1 дүгээр хэлхээний халаалтын буцах Ф-100-тэй шугамд 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр гэмтэл гарч “Хэрэглэгчдэд үйлчлэх 6 дугаар төв”-с 2 автомашин, 8 алба хаагч ажиллаж 12 урт метр шугамыг сольж хэвийн ажиллагаанд оруулсан. Инженерийн шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, цахилгаан хангамжаар иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг тасалдуулахгүй байхад анхаарч, гэнэтийн гэмтэл, саатал гарахаас урьдчилан сэргийлэх, гэмтэл саатлыг засварлах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах талаар Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын “Хэрэглэгчдэд үйлчлэх төв”– 6, 7, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдэд албан бичгээр тус тус хүргүүлэн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ХОЁР: Сайжруулсан шахмал түлшний баруун, зүүн бүсийн үйлдвэр хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч, түлшний чанар, стандартад хяналт тавьж, айл өрхүүдийг сайжруулсан түлшээр тасалдуулахгүй хангах арга хэмжээ авч ажиллах				
2.	Угаарын хийн хордлого, аюулгүй галлагааг хангаж ажиллах талаар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагчийн 022/304 дугаартай мэдэгдэл, зөвлөмжийг дүүргийн 7-19, 20, 24 дүгээр хороодын Засаг дарга, ажлын албанд хүргүүлэн, гэр хорооллын айл өрхүүдэд хөдөлгөөнт автомашины чанга яригчаар 2-3 удаагийн давтамжтайгаар нийт 64 удаагийн сэрэмжлүүлэг мэдээг хүргэн, Онцгой байдлын хэлтсийн http://chd.nema.gov.mn/ пэйж хуудсанд 6 удаагийн постер, 4 төрлийн видео шторкийг бэлтгэн байршуулж ажилласан. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн Агаар орчны бохирдолтой тэмцэх тасаг, Онцгой байдлын хэлтэстэй хамтран дүүргийн нутаг дэвсгэрт байршилтай 78 сайжруулсан шахмал түлш худалдан борлуулах цэг, 8 агуулах, дундын бөөний төвийн худалдан борлуулалт, нөөцийн хүртээмж, галын аюулгүй байдалд хяналт шалгалтыг зохион байгуулан заавар, зөвлөмж өгч ажилласан. 2022 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

	19:00 цагийн байдлаар сайжруулсан шахмал түлшний борлуулалтын 64 цэг түлшний нөөцтэй, 18 цэг түлшний нөөцгүй байна. Дүүргийн хэмжээнд сайжруулсан шахмал түлш борлуулах цэгүүдэд нийт 570 тонн түлшний нөөцтэй, 280 тонн түлшний захиалга өгсөн байна. Хүйтний эрч чангарсантай холбогдуулан агуулахаас 2420 тонн түлшийг цэгүүдэд нийлүүлж, 10642.5 тонн түлшний нөөцтэй байна.			
Үүрэг, даалгавар ГУРАВ: Авто тээврийн шалган бүртгэх товчоо, маршрутын бус замаар Улаанбаатар хот руу түүхий нүүрс нэвтрүүлэхгүй, сайжруулсан шахмал түлш гаргахгүй байхад онцгой анхаарч, хяналт шалгалтыг тогтмол явуулан, хариуцлагыг чангатгаж ажиллах.				
3.	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүүргийн 24 дүгээр хороо Гүнт дэх хяналтын цэгт 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албаны Эргүүл хяналтын хэлтэс, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Агаарын чанарын хяналтын хэлтэс, дүүргийн Цагдаагийн газрын Замын Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн нийт 4 ажилтан, алба хаагчид нийслэл Улаанбаатар хот руу түүхий нүүрс нэвтрүүлэхгүй, сайжруулсан шахмал түлшийг гаргахгүй байх талаар заавар зөвлөмж өгч, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан зөрчил дутагдалгүй ажиллаж байна. Гүнт дэх хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй ажилтан, алба хаагч нар тайлант хугацаанд 315 том оврын болон ачааны тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг хийсэн. Дүүргийн нутаг дэвсгэрийн баталгаат болон баталгаат бус зам буюу 15, 16 дугаар хороо Хайлаастын зам, 17, 18 дугаар хороо Чингэлтэйн зам, 19, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэр Зуслангийн зам, Гүнтийн даваа, Шар хоолойн ам, Шадивлан, Яргайт зэрэг цэгүүдэд 24 цаг 3 ээлжээр хяналт шалгалтыг эрчимжүүлэн “Түүхий нүүрс хэрэглэхийг хорих тухай” 62 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020 оны А/604, А/1112 дугаар хамтарсан тушаал, захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62, 2022 оны 223 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны 11 байгууллагатай хамтран түүхий нүүрс, сайжруулсан шахмал түлшний нөөц, тээвэрлэлт, нийлүүлэлтэд өдөр тутам хяналт тавин ажиллаж байна.		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100
Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Он дуустал үлдэж байгаа хугацаанд дүүрэг болон орлого бүрдүүлэгч байгууллагууд төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн, энэ сарын 25-ны өдрийн дотор бүрэн төвлөрүүлэх.				
4.	Нийслэлийн төсөв: 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийслэлийн төсөвт 12,869.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 14,589.34 сая төгрөг төвлөрүүлж, 113.3%-ийн гүйцэтгэлтэй байна. Дүүргийн төсөв: 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр дүүргийн төсвийн орлогын төлөвлөгөө 155,578,928.6 мянган төгрөг, гүйцэтгэл 135,782,609.2 мянган төгрөг буюу 87.6%-тай байна. Дүүргийн төсвөөс нийслэлийн төсөвт 101,019,706.5 мянган төгрөг төвлөрүүлэхээс 67,665,209.9 мянган төгрөг төвлөрүүлж, 87.2%-ийн биелэлттэй, төсвийн орлогын төлөвлөгөөг 12 дугаар сард өссөн дүнгээр биелүүлэх зорилт дэвшүүлэн нийтлэг ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90

Үүрэг, даалгавар ТАВ: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн жилд өр авлага үүсгэлгүй ажиллах, төсвийг зориулалтын зүйлд зарцуулах, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.

5.	<p>Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43, 388 дугаар тогтоол, дүүргийн Засаг даргын 2022 оны “Төсвийн үр өгөөж, сахилга хариуцлагыг сайжруулах” тухай А/45 дугаар захирамжийг 2022 оны 4/246 дугаар албан бичгээр, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 203, 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтийг хангаж ажиллахыг 4/1596 дугаар албан бичгээр, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг даргын 2022 оны 1/1745 дугаар албан бичгээр харьяа 69 байгууллагын төсвийн шууд захирагч нарт тус тус хүргүүлж, өдөр тутмын үндсэн баримтаар хяналт тавин ажилласан. Өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор дүүргийн харьяа хэлтэс, алба, төр захиргааны байгууллага 17, цэцэрлэг 39, сургууль 18, Өрхийн эрүүл мэндийн төв 16 нийт 90 байгууллага 100% бүрэн хамрагдсан. Улс, нийслэл орон нутгийн хөгжлийн сан, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 23 төрлийн 2,182,976,862 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг байгууллагын даргын тушаалаар бүртгэн авсан. Дүүргийн Засаг даргын 2020 оны А/473 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн 61 ажлыг хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан ба холбогдох материалын бүрдлийг хангуулан, гэрээг дүгнэн ажиллалаа. Дүүргийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/360 дугаар захирамжаар төсөвт өр авлага үүсгэхгүй, зохистой удирдлагыг хэрэгжүүлэн орон нутгийн төсвийн зарлага, сургууль цэцэрлэгийн төсвийн хуваарьт тус тус өөрчлөлт оруулсан.</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90
----	---	---	--	----

Үүрэг, даалгавар ЗУРГАА: Байгууллагууд 2022 онд төлөвлөсөн ажлуудаа эрчимжүүлж хугацаанд гүйцэтгэж дуусгах, ажилтан, албан хаагчдынхаа үр дүнг дүгнэх, ажиллах.

6.	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2022 онд хийж гүйцэтгэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг: - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол; - 2020 оны 24 дүгээр тогтоол “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; - “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого; - Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 32/04 дүгээр тогтоол “Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт”; - Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 02/10 дугаар тогтоол “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”; - Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарлах тухай; - Дүүргийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар 16-ны өдрийн 11 дүгээр тогтоол; - Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай А/83 тоот захирамжтай уялдуулан 6 зорилтын хүрээнд 80 шалгуур үзүүлэлттэйгээр боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Төрийн албаны тухай хуулийн 51.1.4, 61.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг үндэслэн 99</p>	=	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана</p>	90
----	--	---	--	----

	албан хаагчдаас 80 албан хаагч “маш сайн”, 18 албан хаагч “сайн”, 1 албан хаагч “хангалттай” үнэлэгдсэн.			
Үүрэг, даалгавар ДОЛОО: Байгууллагууд ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг мөрдөж хэрэгжүүлж ажиллах.				
7.	<p>“Дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-с Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн талаар ЗДТГ-н харьяа хэлтэс, алба болон ААНБ-н 356 ажилтан, 171 ажил олгогч байгууллагад зөвлөн туслах үйлчилгээг 12 удаагийн сургалт зохион байгуулж, 388 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч холбогдох хуулийн гарын авлага, тараах материалыг өгч ажилласан.</p> <p>“Дүүргийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-с Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ажлын байран дахь осол гэмтлээс урьдчилан сэргийлэх улсын үзлэг зохион байгуулж нийт 38 байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж зөвлөгөө, зөвлөмжийг хүргэн ажилласан.</p> <p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны арга хэмжээг “Аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг хандлагыг хамтдаа төлөвшүүлэе” уриатай зохион байгууллаа. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дүүргийн Улаан загалмайн хороо, Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль хамтран оролцож, давхардсан тоогоор 600 гаруй ажилтан, албан хаагч, иргэд, оюутан залуусыг харууллаа.</p> <p>Дүүргийн Нийтлэг үйлчилгээний газраас Засаг даргын Тамгын газрын байрны гадна хаалга хуучран ажилтан албан хаагч, иргэдийн аюулгүй байдалд эрсдэлтэй болсныг бүрэн шинэчлэн сэргээн засварласан.</p> <p>Дүүргийн 11, 19, 8, 13, 6 дугаар хороодын албан хаагчдын ажиллах нөхцөл болон иргэдийн тав тухтай орчинд үйлчлүүлэх нөхцөлийг ханган нэг цонхны үйлчилгээний хуучин ханыг нурааж талбайг нэмэгдүүлэн, гипсэн хана, уналттай тааз хийж дотор заслын ажил, цахилгааны монтажиг шинэчлэн гэрэлтүүлгийг сольсон. Мөн хэсгийн ахлагч нарын өрөө болон ариун цэврийн өрөөг засварлан, хорооны Засаг даргын өрөөний хана, таазанд засвар хийн, өрөөний шалыг шинэчилж, PVC хулдаас наах, гадна болон дотор хаалгыг шинэчлэн суурилуулах ажлыг гүйцэтгэж, ашиглалтад оруулсан.</p> <p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын гаднах авто зогсоолын үйлчилгээг сайжруулах зорилгоор тэмдэглэгээг сэргээн будах, автомат хаалт хийх, зогсоолыг камержуулах ажлыг авто зогсоолын үйлчилгээ үзүүлэгч “Дабль Бридж” ХХК-тай хамтран хийж гүйцэтгэлээ. Дүүрэг дэх Цагдаагийн газраас байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй 104 эрсдэлийг тооцож, ХЗДХС-ын 2018 оны А/224 дүгээр тушаалын дагуу “Магадлал”, “Нөлөөлөл”-ийг нэг бүрчлэн тооцоолж, 2023 онд үйл ажиллагааны эрсдэл-17, Гадаад хүчин зүйлийн эрсдэл-2,-Дотоод аюулгүй байдлын эрсдэл-1, нийт-20 эрсдэлийг өндөр эрсдэлтэйд тооцон бууруулах төлөвлөгөө гарган, хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.</p>		Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар НАЙМ: Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн амгалан тайван байдлыг хангах, нийгмийн хэв журам, гэмт хэрэг, зөрчилд өртөх, осгож, гэмтэхээс урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх, аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлж ажиллах.				

8.	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Сүхбаатарын талбайд 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс хойш зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаанд оролцогчдын тоо нэмэгдэж, эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрч, нийтийн эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсонтой холбогдуулан бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлэх тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/322 тушаалын дагуу нийт алба хаагчид 9 дэх өдрөө уртасгасан цагаар ажиллаж байна.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	90
Үүрэг, даалгавар ЕС: Нийтийг хамарсан баярын арга хэмжээний үеийн хэв журам сахиулах, бэлэн байдлыг хангах, архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих.				
9.	МХЕГ-ын даргын 2022 оны “Нийтийг хамарсан баяр ёслол цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 01/03 дугаар удирдамжийн дагуу дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсээс “Хүчит шонхор”, “Эрдэнэбулган”, “Юмт Бөмбөгөр”, “Алтжин бөмбөгөр” худалдааны 4 төвд хяналт шалгалт хийж ажиллалаа. Дүүрэг дэх Цагдаагийн газраас нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Сүхбаатарын талбайд 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс хойш зохион байгуулагдаж буй жагсаал, цуглаанд оролцогчдын тоо нэмэгдэж, эрүү, хэв журмын нөхцөл байдал хүндэрч, нийтийн эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсонтой холбогдуулан бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлэх тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/322 дугаар тушаалын дагуу нийт алба хаагчид уртасгасан цагаар ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 115 зорилтод видео шторк, зурагт хуудас бүхий мэдээллийг тус цагдаагийн газрын “Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар” нэртэй цахим хаягт түгээлт хийх ажлыг зохион байгуулж, иргэд, олон нийтээс 132,793 удаагийн түгээлт хийгдэн, 15,888 хүний хандалтыг авсан байна. “Архидан согтуурахтай тэмцэх иргэдийн оролцоо” сэдвээр радиогийн нэвтрүүлэгт 1 удаа оролцож, шинэлэг ажил, арга хэмжээ санаачлах ажлын хүрээнд олны танил, контент бүтээгчидтэй хамтран 15 видео контент, 8 постерыг шинээр хийлгэн, дүүрэг дэх Цагдаагийн газрын нийт алба хаагч нарын сэтгэл зүйн онцлогт тохируулан тэдгээрт ухуулга, нөлөөллийг хүргэх зорилгоор архины хор нөлөөг харуулсан 7 постер мэдээллийг бэлтгэн түгээн ажилласан.	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	70
Үүрэг, даалгавар АРАВ: Нийслэлийн нутгийн захиргааны нийт байгууллагууд “Шинэ жилийн баяр”-ын арга хэмжээг зохион байгуулахдаа төсвийн хөрөнгө зарцуулахгүй байх				
10.	Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Сүхбаатарын талбайд 2022 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс хойш зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаан, цаг үеийн байдлыг харгалзан нийслэлийн Засаг даргын Тамгын газраас өгөгдсөн чиглэлийн хүрээнд дүүргийн “Шинэ жилийн баяр”-ын арга хэмжээг албан ёсоор зохион байгуулахгүй тухай чиглэлийг төрийн байгууллагуудад хүргүүлсэн. Дүүрэг дэх Цагдаагийн газраас “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5, 15.1.7 дахь заалтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэх тухай Цагдаагийн ерөнхий газрын дэд даргын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны	=	Үүрэг даалгаврын хэрэгжилт хангагдана	100

өдрийн 3/418 дугаар үүрэг чиглэлийн дагуу байгууллага, хамт олон, найз нөхдийн хүрээнд “Шинэ жил” тэмдэглэхгүй байх, тэмдэглэлт өдрүүдийг хамт олон, найз нөхөд, гэр бүлийн хүрээнд архи согтууруулах ундаа хэрэглэхгүйгээр зөв зохистой хэрэглэх, аливаа хэлбэрээр сахилга ёс зүйн зөрчилд холбогдохгүй байх чиглэлийг хүргүүлэн ажиллаж байна.			
--	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ